



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/333

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Геодези, зураг зүйн тухай хуулийн 5.5.12 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:


1.“Газар зүйн нэрийг тогтоох, тодотгох, солбицолжуулах, баталгаажуулах, газар зүйн нэрийн зураг зохиох дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан дүрмийг олон нийтэд мэдээлэх, нийтээр дагаж мөрдүүлэх, хэрэгжилтийг хангуулах ажил зохион байгуулахыг Геодези, зураг зүйн хэлтэс (Д.Мөнхцэцэг)-т даалгасугай.

3.Дүрмийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Геодези, зураг зүйн хэлтэс (Д.Мөнхцэцэг)-т даалгасугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын газар (Б.Энхболд)-т даалгасугай.

ДАРГА



А.ЭНХМАНЛАЙ




ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Газар зохион байгуулалт, геодези,
зураг зүйн ерөнхий газрын 2024 оны
11 дүгээр сарын 22-ны өдрийн А/333
дугаар тушаалын хавсралт



ГАЗАР ЗҮЙН НЭРИЙГ ТОГТООХ, ТОДОТГОХ, СОЛБИЦОЛЖУУЛАХ,
БАТАЛГААЖУУЛАХ, ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН ЗУРАГ ЗОХИОХ ДҮРЭМ

УЛААНБААТАР ХОТ
2024 он



1.Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 04/2019 дугаар техникийн даалгаврыг баримтлан боловсруулав.

2.Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/333 дугаар тушаалын хавсралтаар батлав.

3.Газар зүйн нэрийг тогтоох, тодотгох, солбицолжуулах, баталгаажуулах, газар зүйн нэрийн зураг зохиох дүрмийг 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

БОЛОВСРУУЛСАН:

Ю.ЧҮЛТЭМ	МОНГОЛ УЛСЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН УХААНЫ МАГИСТР
Б.МӨНХЗУЛ	МОНГОЛ УЛСЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН УХААНЫ МАГИСТР
Д.МӨНХЦЭЦЭГ	МОНГОЛ УЛСЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР, ДОКТОРАНТ
Д.УНДАРМАА	МОНГОЛ УЛСЫН ГЕОДЕЗИЙН МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР
Ц.ОРЛОГО	ЗУРАГ ЗҮЙН ИНЖЕНЕР

ХЯНАН ТОХИОЛДУУЛГА ХИЙСЭН:

Ц.ОЮУНЧИМЭГ	МОНГОЛ УЛСЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН УХААНЫ МАГИСТР
-------------	---

ШҮҮМЖ БИЧСЭН:

Б.ОЮУНХАНД	МОНГОЛ УЛСЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР, ДОКТОР
------------	-------------------------------------

Энэхүү дүрмийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын зөвшөөрөлгүйгээр бүрэн болон хэсэгчлэн хувилах, олшруулах, тараахыг хориглоно.

ГАРЧИГ

ГАРЧИГ	3
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	4
ХОЁР. ГАЗАР ЗҮЙН НЭРИЙГ ТОГТООХ, ӨӨРЧЛӨХ.....	4
ГУРАВ. ГАЗАР ЗҮЙН НЭРИЙГ ТОДОТГОХ.....	5
ДӨРӨВ. ГАЗАР ЗҮЙН НЭРИЙГ БАТАЛГААЖУУЛАХ.....	7
ТАВ. ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН ЗУРАГ ЗОХИОХ	8
ЗУРГАА. ГАЗАР ЗҮЙН НЭРИЙГ ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ, АШИГЛАХ.....	11
ДОЛОО. БУСАД.....	12
Хавсралт 1	14
Хавсралт 2	15
Хавсралт 3	16
Хавсралт 4	17
Хавсралт 5	18
Хавсралт 6	19
Хавсралт 7	20
Хавсралт 8	21
Хавсралт 9	22
Хавсралт 10	23
Хавсралт 11	25
Хавсралт 12	27
Хавсралт 13	28
Хавсралт 14	31
Хавсралт 15	33
Хавсралт 16	34

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү дүрмийг Газар зүйн нэрийг тогтоох, тодотгох, солбицолжуулах, баталгаажуулах, газар зүйн нэрийн зураг зохиох үйл ажиллагаанд дагаж мөрдөнө.

1.2.Энэхүү дүрэмд Хавсралт 16-д дурдсан норматив баримт бичгийн холбогдох заалтуудыг ишлэл болгон ашигласан.

1.3.Энэхүү дүрэмд тусгагдсан газар зүйн нэрийн нэр томъёоны тодорхойлолтыг Хавсралт 15-д заагдсан утгаар ойлгоно.

1.4.Газар зүйн нэрд Геодези, зураг зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-ын 11.3.1, 11.3.2, 11.3.3 дахь заалтад заасан объектын нэр хамаарна.

ХОЁР. ГАЗАР ЗҮЙН НЭРИЙГ ТОГТООХ, ӨӨРЧЛӨХ

2.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь Улсын Их Хурлаар батлагдсан газар зүйн нэрийг өөрчлөх, хүчингүй болгох хүсэлтээ Хавсралт 10-д заасан маягтын дагуу хүргүүлнэ.

2.2.Шинээр буй болсон объектод нэр өгөх хүсэлтийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Хавсралт 11-д заасан хүсэлтийн маягтын дагуу аймаг, сум, нийслэл, дүүргийн Геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гаргана.

2.3.Газар зүйн объектод шинээр нэр өгөх, нэрийг өөрчлөх хүсэлт гаргагч нь Хавсралт 11, 10-д заасан хүсэлтийн маягтыг бөглөсөн байх ба хүсэлтэд газар зүйн объектын байршлыг харуулсан газрын зураг болон 2-3 талаас нь авсан гэрэл зураг хавсаргасан байна.

2.4.Газар зүйн объектод нэр өгөх, өөрчлөхөд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/202 дугаар тушаалаар батлагдсан “Газар зүйн нэрийн мэдээллийн сангийн загвар” дахь үндсэн ангилал, дэд ангилал, анхдагч ангилал дахь болон “Монгол газар нутгийн дэвсгэр нэрийн зурагт тайлбар толь” дахь заасан дэвсгэр нэрээр ангилж нэрлэнэ.

2.5.Шинээр бий болсон газар зүйн объектод өгөх нэр нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.5.1.шинээр худаг, булаг, шанд, гол, нуур бий болсон тохиолдолд орчны газрын газар зүйн нэрийг үндэслэх;

2.5.2.тухайн объектын онцлог шинж чанарыг харгалзах;

2.5.3.нэг объект нэг нэртэй байх;

2.5.4.ижил дэвсгэр нэртэй зэргэлдээ орших газар зүйн объектын оноосон нэрийг давхардуулж өгөхгүй байх;

2.5.5.газар зүйн нэр нь утга төгөлдөр, зөв агуулгатай байх;

2.5.6.газар зүйн нэр нь 3-аас илүүгүй үгнээс бүрдсэн байх;

2.5.7.газар зүйн нэр нь тухайн объектын байгалийн шинж, мөн чанарт тохирсон байх;

2.5.8.хоёр буюу түүнээс дээш ижил төрлийн объектыг хооронд нь тодорхой онцлогоор нь ялган нэрлэх (тухайлбал дээд, доод, баруун, зүүн, шинэ, хуучин, улаан, хар);

2.5.9.нэр өгөх объектын ойролцоо орших объектын нэрийг ашиглан зүг чиг, өнгө, цаг хугацааны тодотголтой нэрлэх.

2.6.Газар зүйн объектод дараах байдлаар нэр өгөхийг хориглоно. Үүнд:

- 2.6.1. гадаад нэр, гадаад үг хэллэгээр нэрлэх;
- 2.6.2. арьс, өнгө, итгэл үнэмшил, хүйс, улс төрийн харьяалал, нийгмийн бусад хүчин зүйлийн хувьд ялгаварлан гадуурхсан нэр өгөх;
- 2.6.3. арилжааны зориулалттай бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, аж ахуйн нэгж, байгууллагыг сурталчилсан нэр өгөх;
- 2.6.4. хүний нэрээр нэрлэхээс зайлсхийх;
- 2.6.5. зохисгүй, бүдүүлэг, далд санаа бүхий нэр өгөх.

2.7. Газар зүйн нэрийг дараах тохиолдолд өөрчилж болно. Үүнд:

- 2.7.1. уугуул иргэд нь нэрлэж заншсан уламжлалт, түүхэн газар зүйн нэрийг сэргээх хүсэлт тавьсан;
- 2.7.2. адил төрлийн объектын нэр нь ижил нэрнээс болж зам, тээвэр, харилцаа холбоо, эмнэлэг, онцгой байдал, зам тээвэр, харилцаа холбоо, бусад байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл учруулж байвал;
- 2.7.3. тухайн объектын мөн чанарт тохирохгүй, этгээд хэллэгээр нэрлэгдсэн;
- 2.7.4. хэл зүй, зөв бичгийн дүрэмд нийцэхгүй;
- 2.7.5. дүрмийн бус утга, аялга, хэллэг, дуудлагатай, энгийн ярианы хэллэгтэй;
- 2.7.6. түүхийн хувьд алдаатай нэрээр нэрлэгдсэн;
- 2.7.7. монгол хэлнээс өөр хэл дээр нэрлэгдсэн.

2.8. Газар зүйн нэрийн судалгаа, нэрийг тодотгох ажлыг геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж нь нутгийн иргэд, бүх шатны Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, газар зүйн нэрийн салбар зөвлөлтэй хамтран гүйцэтгэнэ.

2.9. Газар зүйн нэрийн судалгаа тодруулалт хийх ажилд оролцох нутгийн иргэд нь газар орныхоо түүх, домог, уламжлалт нэрийг сайн мэддэг, шударга, ахмад настай хүн байна.

ГУРАВ. ГАЗАР ЗҮЙН НЭРИЙГ ТОДОТГОХ

3.1. Газар зүйн нэрийн тодотголыг дараах тохиолдолд хийнэ. Үүнд:

- 3.1.1. Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт 1980-1987 онд хийгдсэн газар зүйн нэрийн судалгаагаар орхигдсон уламжлалт нэр байгаа бол;
- 3.1.2. газар зүйн нэрийн зургийг шинэчлэх бол;
- 3.1.3. газар зүйн объект болон нэрийн байршлыг байр зүйн зурагт алдаатай тусгасан бол;
- 3.1.4. Улсын Их Хурлаар батлагдсан газар зүйн нэрийг алдаатай бичиж, тэмдэглэсэн бол;
- 3.1.5. газар зүйн нэрийн байршлыг солбицолжуулах бол.

3.2. Газар зүйн нэрийг тодотгох ажлыг бэлтгэл ажил, суурин судалгаа, хээрийн тодотгол, суурин боловсруулалт гэсэн үе шаттайгаар гүйцэтгэнэ.

3.3. Газар зүйн нэрийн тодотголын бэлтгэл ажлын үед дараах баримт мэдээллийг цуглуулж бэлтгэнэ. Үүнд:

- 3.3.1. газар зүйн нэрийг баталсан тогтоол, шийдвэр;
- 3.3.2. Улсын Их Хурлаар батлагдсан газар зүйн нэрийн жагсаалт;
- 3.3.3. газар зүйн нэрийн мэдээллийн сан;
- 3.3.4. газар зүйн нэрийн зураг (сум, дүүрэг бүрээр);
- 3.3.5. газар зүйн нэрийн тодотголд ашиглах 1:25000-1:100000-ны масштабтай байр зүйн зураг;

Засгийн газрын хэрэгжүүлэх ажил
ГАЗАР ЗОХИОН БАЙГАА, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨН ХЭТЭГ

ЭХ ХУВЬ

Тодотголын акт нэр: *Тушаал*
Хугацаа: *А/333*

3.3.6.1980-1987 онд газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийсэн 1:100000-ны масштабтай байр зүйн зураг;

3.3.7.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тогтоосон зарлиг, тогтоол, шийдвэр, газрын зураг;

3.3.8.бусад баримт мэдээлэл.

3.4.Газар зүйн нэрийн тодотголын суурин судалгаагаар дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

3.4.1.Улсын Их Хурлаар баталсан газар зүйн албан ёсны нэрийг 1:25000-1:100000-ны масштабтай байр зүйн зураг дээрх газар зүйн нэртэй харьцуулан судлан Хавсралт 1-ийн дагуу жагсаалт гаргана;

3.4.2.газар зүйн нэрийн тодруулалт хийсэн суурь зураг дээрх нэрийг тодотгол хийхэд ашиглах 1:25000-ны масштабтай байр зүйн зураг (1:25000-ны масштабтай байр зүйн зураг байхгүй тохиолдолд 1:50000, 1:100000-ны масштабтай байр зүйн зураг)-т оруулж тэмдэглэн, хээрийн тодотголд ашиглахаар ажлын зураг болгон хэвлэж бэлтгэх. Энэ зураг нь цаашид газар зүйн нэрийн эх зураг болно.

3.5.Хээрийн тодотголоор дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

3.5.1.газар зүйн нэрийн хээрийн тодотгол хийх үйл ажиллагааг орон нутгийн газар зүйн нэрийн салбар зөвлөлд танилцуулах, газарчнаар ажиллуулах иргэдийн нэрсийг тушаал шийдвэрээр гаргуулах;

3.5.2.хээрийн тодотголын ажилд газарчнаар ажиллах хүмүүс нь орон нутгийн ахмад настан, уугуул оршин суугч, нутгийнхаа иргэдэд хүндлэгдсэн 2-оос доошгүй иргэдийн төлөөлөл байна. Уг иргэд нь газар нутгаа, уламжлалт нэр, түүх, домог сайн мэддэг хүн байх;

3.5.3.хээрийн тодотголыг нийт нутаг дэвсгэрийг хамруулан явж хийх, батлагдаагүй орхигдуулсан нэр, нэрийг алдаатай бичсэн, байршлыг газрын зурагт буруу тэмдэглэсэн нэрийг олж илрүүлэх, арилахгүй балаар газрын зурагт тэмдэглэх, нэр бүрийн солбицлыг тодорхойлж жагсаалт гаргах;

3.5.4.Улсын Их Хурлаар нэр нь батлагдаагүй, шинээр бий болсон объектыг тодотгон газар зүйн нэрийн тодруулалт хийж буй 1:25000-1:100000-ны масштабтай байр зүйн зураг дээр байршлаар тэмдэглэх, жагсаалт гаргах, 2-3 талаас нь гэрэл зураг авч хүсэлтийн маягтыг Хавсралт 11-д заасны дагуу бөглөх;

3.5.6.газар зүйн нэрийн хээрийн тодотголын ажилд газарчнаар ажилласан иргэдийн хувийн мэдээллийг авч (овог, нэр, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар, тодотголоор ажилласан огноо гэх мэт) газар зүйн объектын нэр үнэн зөв болохыг гарын үсгээр баталгаажуулахад Хавсралт 9-ийг ашиглана;

3.5.7.газар зүйн нэрийн тодотголын ажилд Захиалагч байгууллагаар захиалагчийн хяналт хийлгүүлсэн байх.

3.6.Суурин боловсруулалтын дор дурдсан ажлыг хээрийн судалгаа, тодотголын үр дүн, холбогдох баримт бичгийг үндэслэн гүйцэтгэнэ. Үүнд:

3.6.1.Улсын Их Хурлаар батлагдаагүй, судалгаагаар илрүүлсэн уламжлалт газар зүйн нэрийн жагсаалтыг Хавсралт 2-ын дагуу гаргах;

3.6.2.газар зүйн нэрийг тодотгох явцад Улсын Их Хурлаар батлагдахдаа зөрүүтэй, үг үсгийн алдаатай, өөр нэрээр батлагдсан газар зүйн нэрийн жагсаалтыг Хавсралт 5-ын дагуу гаргах;

3.6.3.газар зүйн нэрийн тодотгол хийсэн газрын зурагт байршлын хувьд алдаатай тэмдэглэсэн нэрийн жагсаалтыг Хавсралт 4-ийн дагуу гаргах;

3.6.4.тодотголоор зэргэлдээх аймаг, сумын хилийн заагт орших газар зүйн нэр, хилийн цэсийн эргэлтийн цэгийн нэр зөрүүтэй нэрлэсэн тохиолдолд жагсаалтыг Хавсралт 5-ын дагуу гаргаж сум, дүүргийн газар зүйн нэрийн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Хавсралт 7-ын дагуу тэмдэглэл хөтлөх;

3.6.5.шинээр тодотгосон газар зүйн объектуудын нэрийн жагсаалтыг Хавсралт 6-ын дагуу гаргах;

3.6.6.Улсын Их Хурлаар батлуулах газар зүйн нэрийг дэвсгэр нэрээр цагаан толгойн үсгийн дараалалд оруулж аймаг, сум, нийслэл, дүүрэг бүрээр жагсаалтыг Хавсралт 8-ын дагуу гаргах;

3.6.7.газар зүйн нэрийн тодотгол хийсэн байгууллага нь энэхүү дүрмийн 5-р бүлэгт заасны дагуу төслийн мэдээллийн сан, газар зүйн нэрийн зургийг зохион хэвлэж, Захиалагч байгууллагад хүлээлгэн өгөх;

3.6.8.газар зүйн нэрийг тодотгох, хэмжилт судалгааны ажлын тайлан бичих;

3.6.9.шинээр батлуулах газар зүйн нэрийн жагсаалт гаргаж, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж тогтоол гаргуулах бэлтгэл хангах.

ДӨРӨВ. ГАЗАР ЗҮЙН НЭРИЙГ БАТАЛГААЖУУЛАХ

4.1.Сум, дүүргийн Газар зүйн нэрийн салбар зөвлөл нь иргэн, байгууллагаас гаргасан шинээр бий болсон газар зүйн объектод нэр өгөх, өөрчлөх хүсэлтийг Хавсралт 11, Хавсралт 10-д заасан маягтын дагуу хүлээн авч, тус дүрмийн 2.5, 2.6, 2.7-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд дүгнэлт гарган, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

4.2.Газар зүйн нэрийн тодотголоор ирүүлсэн баримт бичиг нь энэхүү дүрмийн шаардлагыг хангасан эсэхийг сум, дүүргийн Газар зүйн нэрийн салбар зөвлөл хянаж сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх эсэх талаар санал, дүгнэлт гаргана.

4.3.Шинээр бий болсон газар зүйн объектод нэр өгөх, өөрчлөх хүсэлтэд сум, дүүргийн газар зүйн нэрийн салбар зөвлөлөөс гаргасан санал, дүгнэлтийг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж, шаардлага хангасан бол тогтоол гаргаж, аймаг, нийслэлийн Геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

4.4.Сум, дүүргийн Геодези, зураг зүйн асуудал хариуцсан орон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн газар зүйн нэрийн тодотголын баримт бичиг нь энэхүү дүрмийн шаардлагыг хангасан эсэхийг аймаг, нийслэлийн Газар зүйн нэрийн салбар зөвлөл хянан, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх эсэх талаар санал, дүгнэлт гаргана.

4.5.Газар зүйн нэрийн тодотголоор Улсын Их Хурлаар батлах газар зүйн нэрэнд аймаг, нийслэлийн Газар зүйн нэрийн салбар зөвлөлөөс гаргасан саналыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж гарсан тогтоолыг Геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

4.6.Геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь шинээр буй болсон газар зүйн объектод нэр өгөх, өөрчлөх, тодотголоор тогтоосон нэрийг батлуулахаар ирүүлсэн баримт бичиг үндэслэлтэй эсэхийг лавлах, толь бичиг, эрдэмтэн судлаачид, газрын зураг болон бусад баримтаас нягталж баталгаажуулна.

4.7.Геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Газар зүйн нэрийн зөвлөлөөр газар зүйн объектод нэр өгөх, нэрийг өөрчлөх тухай санал, холбогдох баримтыг хэлэлцүүлж зөвлөмж, санал, дүгнэлт гаргуулна.

4.8.Геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага газар зүйн объектод нэр өгөх, нэрийг өөрчлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэрэгцээ шаардлага, тандан судалгаа, үзэл баримтлалын төслийг

боловсруулан Газар зүйн нэрийн зөвлөлөөр хэлэлцүүлж, зөвлөмж, санал, дүгнэлтийг холбогдох баримтын хамт Засгийн газарт хүргүүлнэ.

4.9.Геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага газар зүйн объектод нэр өгөх, нэрийг өөрчлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж батлуулах ажлыг зохион байгуулна.

4.10.Геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага газар зүйн объектод нэр өгөх, нэрийг өөрчлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газарт хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

4.11.Засгийн газар Газар зүйн нэрийг хэлэлцэж, батлуулахаар Монгол Улсын Их Хуралд өргөн барина.

ТАВ. ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН ЗУРАГ ЗОХИОХ

5.1.Газар зүйн нэрийн мэдээллийн сан, газар зүйн нэрийн зургийг зохиох, улсын хэмжээний газар зүйн нэрийн мэдээллийн санг батлагдсан загвар, MNS 6925-3:2021 стандартыг баримтлан байгуулна.

5.2.Газар зүйн нэрийн мэдээллийн сангийн батлагдсан загварын дагуу газар зүйн нэрийн хамрах хүрээг цэгээр, шугамаар, талбайгаар дүрсэлж зураглана. Энэ ажлыг гүйцэтгэхэд батлагдсан зааврыг мөрдлөг болгоно.

5.3.Геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Улсын Их Хурлаар баталсан газар зүйн нэрийг, аймаг, нийслэлийн геодези, зураг зүйн асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан газар зүйн нэрийг газар зүйн нэрийн мэдээллийн санд бүртгэж, нийтэд мэдээлнэ.

5.4.Газар зүйн нэрийн мэдээллийн сан нь бусад салбарын мэдээллийн сантай мэдээллээ харилцан солилцдог, бүх төрлийн газрын зурагт орон зайн суурь мэдээлэл байхаар зохион байгуулагдана.

5.5.Батлагдсан газар зүйн нэрийг газрын зурагт тэмдэглэх, газар зүйн нэрийн зураг зохиох, хэвлүүлэх асуудлыг Геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна.

5.6.Газар зүйн нэрийн мэдээллийн санд дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- 5.6.1.газар зүйн нэрийн дахин давтагдашгүй дугаар;
- 5.6.2.аймаг, нийслэлийн нэр;
- 5.6.3.сум, дүүргийн нэр;
- 5.6.4.баг, хорооны нэр, дугаар;
- 5.6.5.газар зүйн оноосон нэр;
- 5.6.6.газар зүйн дэвсгэр нэр;
- 5.6.7.объектын байршлын солбицол (уртраг, өргөрөг, өндөр);
- 5.6.8.нэр батлагдсан огноо, баталсан этгээд (тогтоол, шийдвэр);
- 5.6.9.газар зүйн нэрийн галиглал;
- 5.6.10.газар зүйн нэрийн хувийн хэрэг (Хавсралт 12);
- 5.6.11.газар зүйн нэрийг шинээр олгох, өөрчлөх хүсэлт болон түүний хавсралт баримтын хуулбар;
- 5.6.12.бусад.

5.7.Газар зүйн оноосон болон дэвсгэр нэрийг латин үсгээр галиглахдаа MNS 5217:2012 стандартыг мөрдөнө.

5.18.Газар зүйн нэрийн зурагт 8-14 хүртэлх өндөртэй "Arial", "Times New Roman" үсгийн фонтыг газар зүйн нэр, тайлбар бичиглэлд Хүснэгт – 1-д оруулсны дагуу хэрэглэнэ.

Хүснэгт – 1

Нэр	Үсгийн фонд, өндөр
Газар зүйн бүх нэр	<p>ДАРХАН - Times New Roman 11 <i>ТУСГАЛТЫН НУРУУ</i> – Arial 12, Ханан уул - Arial 12 Цагаан уул - Arial 11,10 <i>Гүндэнгийн хяр</i> – Times New Roman 11,10, <i>Холбоо толгой</i> – Times New Roman 11,10, <i>Өлийн даваа, Молцог элс</i> – Times New Roman 12, 11, <i>Мойлтын нам</i> – Times New Roman 10, 9, <i>Өгөөмөрийн хөндий</i> – Arial 14-9, <i>Өгөөмөрийн хөндий</i> – Arial 9, <i>Марцатын хоолой</i> - Times New Roman 14, <i>Шар хоолой</i> - Times New Roman -12, <i>Мэнгийн тал</i> - Times New Roman -12, 11 <i>Хужиртын толгод дэл ухаа, гүвээ, хошуу, хэц</i> - Times New Roman -11,10, Цагаан нуур, Орхон гол – Times New Roman 10- 8, <i>Хөшөөтийн горхи</i> - Times New Roman 8, <i>Савангийн худаг, Оргихын булаг. Жажийн шанд, Дэлгэр Жаргалантын рашаан</i> - Times New Roman 9, 8</p>

5.19.Газар зүйн объект нэрийг хар өнгөөр үзүүлэх ба газар зүйн объектын эзлэх орон зайгаас хамааран бичиглэлийн өндөр болон нарийсалтыг сонгоно.

5.20.Уул, нуруу, говь, тал, хөндий, хоолой гэх мэт асар уудам талбай эзэлсэн байгалийн объектуудын нэрийг зурагт байрших байршил, эзлэх талбайд багтаан бичнэ.

5.21.Ам, ганга, гол, горхи, жалга, сайр, суваг, шуудуу зэрэг үргэлжилсэн объект, байгууламжийн нэрийг тэдгээрийн дүрслэл дагуу бичиж байрлуулна.

5.22.Томоохон голын нэрийг 15-20 см тутамд давтаж бичнэ. Хэрэв том үсэг хэрэглэсэн бол хоёроос доошгүй удаа байрлуулна. Голын эхэнд нэрийг заавал бичнэ. Голын бэлчирт, цутгалуудаас эх гол нь ялгагдахаар нэрийг байрлуулна.

5.23.Ус зүйн (гол, нуур, тойром, булаг гэх зэрэг) нэрийг цэнхэр өнгөөр үзүүлнэ.

5.24.Газар зүйн нэрийн зурагт гол (ширгэдэг, ширгэдэггүй гэж ангилах), мөрөн, нуур, тойром, усан сан, булаг, худаг зэрэг ус зүйн элементүүдийг тухайн зургийн масштабаас хамааран дүрсэлнэ.

5.25.Нуурын эргийн шугамыг ширгэдэг, ширгэдэггүй хэмээн ялган үзүүлэх, нэрийг нуурын талбайгаас хамааран нуурын гадна талд бичиж, томоохон нуурын нэрийг нуурын талбай дотор үзүүлнэ. Мөн нуурыг давстай, давсгүйгээр ангилан дүрсэлнэ.

5.26.Газар зүйн нэрийн зурагт хот, суурин газрыг дэлгэрэнгүй үзүүлэхээс гадна уурхай, жуулчны бааз, амралт, сувилал, түүх дурсгал, хөшөө, баримал, сүм хийд зэрэг тусдаа орших, хүний гараар бүтээгдсэн объектуудыг үзүүлнэ.

5.27.Газар зүйн объектыг ялган үзүүлэх, уншигдалтыг сайжруулах зорилгоор газар зүйн нэрийн бичиглэлийн өндөр, өргөнийг өгөгдсөн хэмжээнээс ихэсгэх буюу багасгаж болно.

5.28.Газар зүйн нэрийн зургийн эхийг Зураг зүйн инженер зөвлөх зэрэгтэй инженер хянана.

5.29.Аймаг, сум, нийслэл, дүүрэг, баг, хорооны нэрийг тод өнгөөр үсгийн фонтыг бүгд том үсгээр үзүүлэх ба газар зүйн нэрийн зургийн зохиолтын болон хэвлэлийн эхийг зураглаж буй газар нутгийн хэлбэр, хэмжээтэй уялдуулан бэлтгэнэ.

5.30.Газар зүйн нэрийн зурагт 10x10 см-ийн торлолын нэрийг тоо болон кирилл үсгээр Хавсралт 13-ын дагуу тэмдэглэнэ.

5.31.Газар зүйн нэрийн зургийг хэвлэхдээ CMYK 4 өнгөний систем эсвэл RGB өнгөний систем ашиглана.

5.32.Газар зүйн нэрийн зурагт дараах бичиглэлийг үзүүлнэ. Үүнд:

5.32.1.газрын зургийн нэр;

5.32.2.газрын зургийн тоон болон шугаман масштаб;

5.32.3.таних тэмдэг;

5.32.4.зүг, чигийн тэмдэг;

5.32.5.хиллэж буй улс, аймаг, сум, нийслэл, дүүргийн нэр;

5.32.6.газар зүйн нэрийн тодотгол хийсэн гүйцэтгэгч хуулийн этгээдийн нэр, инженер, техникийн ажилтнуудын овог нэр, орон нутгийн газарчны овог нэрийг зөвхөн төслийн газар зүйн нэрийн зурагт тусгана;

5.32.7.газар зүйн нэрийн тодотгол хийсэн огноо;

5.32.8.газар зүйн нэрийн зургийг зохиосон болон хянасан инженерийн овог, нэр зөвхөн төслийн газар зүйн нэрийн зурагт тусгана.

5.33.Газар зүйн нэрийн зурагт газар зүйн үндсэн агуулгыг үзүүлэх таних тэмдгийг газар зүйн мэдээллийн системийн ArcGIS программын тэмдэгтүүдээс Хавсралт 14-д зааснаар сонгоно. Мөн загвар файл (style file) бэлтгэнэ.

5.34.Газар зүйн нэрийн зургийн үндсэн агуулгыг таних тэмдгээр үзүүлнэ.

ЗУРГАА. ГАЗАР ЗҮЙН НЭРИЙГ ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ, АШИГЛАХ

6.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг газар зүйн албан ёсны нэрийн мэдээллээр хангах, газар зүйн нэрийг ашиглах, хамгаалах асуудлыг аймаг, сум, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга болон геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.

6.2.Шинээр буй болсон газар зүйн объектод нэр өгөх, өөрчлөх, газар зүйн нэрийг тодотгох, хамгаалах зорилгоор газар зүйн нэртэй холбогдон гарсан аливаа шийдвэр, нэр өгөх, өөрчлөхтэй холбоотой нотлох баримтууд, батлагдсан нэрийн жагсаалт, хээрийн тодруулалтын ажилд ашигласан газар зүйн нэрийн эх зураг зэргийг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байнга хадгална.

6.3.Газар зүйн нэрийн тодотголын тайлан, мэдээллийн сан, нэрийн зураг (*tiff, *jpeg, *png, *pdf өргөтгөлөөр CD, DVD-д), батлагдсан нэрийн жагсаалтыг нийслэл, сумаар ялган цагаан толгойн үсгийн дараалал, дэвсгэр нэрээр хэвлэж геодези, байр зүйн зүйн улсын нэгдсэн санд хадгална.

6.4.Газар зүйн нэрийг дараах хэлбэрээр нийтэд хүргэнэ. Үүнд:

6.4.1.газар зүйн нэрийн мэдээллийн санг геодези, зураг зүйн цахим систем геопорталаар дамжуулах;

6.4.2.байгууллагын веб хуудсаар дамжуулан шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нэрийн мэдээллийг хүргэх;

6.4.3.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийн дагуу газар зүйн нэрийн лавлагаа өгөх;

6.4.4.газар зүйн нэрийн газрын зураг, альбом хэвлэх;

Засгийн газрын зэрэгжүүлэгч агентлаг
ГАЗАР ЭСХИШ БАНГ, ГАЗАР
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН БРӨМӨЛӨӨ

ЭХ ХУВЬ

Тусгай зөвшөөрлийн акт нэр: *Тусгай*
А/333

бүлгийн үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох үүргийг Геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүлээнэ.

7.4.Газар зүйн албан ёсны нэрийн тухай мэдээллээр хангах, газар зүйн нэрийг зөв бичих, хэрэглэх, хамгаалах, хээрийн тодотгол хийх, Газар зүйн нэрийн мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардагдах санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

7.5.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлтээр газар зүйн нэр шинээр өгөх, өөрчлөхөд шаардагдах зардлыг хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага санхүүжүүлнэ.

7.6.Улсын болон орон нутгийн санхүүжилтээр хийж буй газар зүйн нэрийн тодотголын ажлын тайланг геодези, зураг зүйн зүйн улсын нэгдсэн санд хүлээлгэн өгсний дараа ажлыг дууссанд тооцно.

7.7.Энэхүү дүрмийн хэрэгжилтэд Геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

7.8.Газар зүйн нэрийн тодруулалтын ажлын явцад үүссэн баримтыг албан хэрэг хөтлөлт, архивын дүрэм, журмын дагуу бүрдүүлж архивт шилжүүлнэ.

**Улсын Их Хурлаар батлагдсан нэрийн тодруулалт хийсэн суурь зурагт
байршлаараа буруу тэмдэглэгдсэн газар зүйн нэрийн судалгаа**

..... аймаг (нийслэл) сум (дүүрэг)

д/д	Улсын Их Хурлаар батлагдсан газар зүйн нэр	1:25 000-ны масштабтай байр зүйн зургийн нэрэлбэр	суурь зураг дахь солбицол		зөв байршлын солбицол	
			өргөрөг	уртраг	өргөрөг	уртраг

Газар зүйн нэрийг тодотгох судалгаа хийсэн:

(овог нэр, байгууллага, албан тушаал)

Зөрүүтэй нэрлэж буй газар зүйн нэрийн жагсаалт

..... аймгийн сумын хил заагт байгаа газар зүйн нэр зэргэлдээх, аймгийн сумын газар зүйн нэрийн зөрүүтэй байдлын талаарх мэдээлэл

д/д	Газар зүйн нэр	Зэргэлдээх суманд нэрлэж буй газар зүйн нэр	Солбицол		Хэрхэн шийдвэрлэсэн (тайлбар)
			өргөрөг	уртраг	
1.					
2.					
3.					

Газар зүйн нэрийг тодотгох судалгаа хийсэн:

(овог нэр, байгууллага, албан тушаал)

Шинээр буй болсон газар зүйн объектуудын нэрийг тодотгосон судалгаа

..... аймаг (нийслэл) сум (дүүрэг)

д/д	Шинээр бий болсон объект газар зүйн нэр	Газар зүйн дэвсгэр нэр	1:25000-ны масштабтай байр зүйн зургийн нэрэлбэр	Солбицол	
				өргөрөг	уртраг

Газар зүйн нэрийг тодотгох судалгаа хийсэн:

(овог нэр, байгууллага, албан тушаал)

..... он сар өдөр

Газар зүйн нэрийн тодотголын судалгаагаар зөрүүтэйгээр нэрлэж байгаа газар зүйн нэрийн талаар хэлэлцсэн хурлын тэмдэглэл

..... аймгийн сумын нутгийн газар зүйн нэрийн тодотголын судалгаагаар зөрүүтэйгээр нэрлэж байгаа газар зүйн нэрийн талаар хэлэлцсэн хурлын тэмдэглэл

..... оны сарын -ны өдрийн цагт хурал эхлэв.

Хуралд оролцсон:

..... сумын (дүүрэг)-ийн Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн дарга, гишүүд, иргэд (Албан тушаал, овог нэр,)

Хэлэлцсэн асуудал:

.....
.....

АСУУЛТ, ХАРИУЛТ, САНАЛ нь:

Шийдвэрлэсэн нь:

.....
.....
.....
.....

..... оны сарын -ны өдрийн цагт хурал дуусав.

Тэмдэглэл хөтөлсөн: (Албан тушаал, овог нэр, гарын үсэг)

Хянасан: Хуралд оролцсон:

..... сумын (дүүрэг)-ийн Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн дарга, гишүүд, иргэд (Албан тушаал, овог нэр, гарын үсэг)

..... аймгийн сумын газар зүйн нэрийн судалгаа,
нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх

Улсын Их Хурлаар батлуулах газар зүйн нэр

д/д	УИХ-аар шинээр батлагдах газар зүйн нэр	1:25000-ны масштабтай байр зүйн зургийн нэрэлбэр	Солбицол	
			өргөрөг	уртраг
1.	Дэвсгэр нэр: Ам			
2.				
3.				
4.				
5.				
6.	Дэвсгэр нэр: Булаг			
7.				
8.				
9.				
10.				

Газар зүйн нэрийг тодотгох судалгаа хийсэн:

(овог нэр, байгууллага, албан тушаал)

.....он сар өдөр

**Газар зүйн нэрийн хээрийн тодотголын ажилд газарчнаар ажилласан
иргэний нотолгоо**

.....аймаг (нийслэл)сум (дүүрэг)

д/д	Иргэний овог, нэр	Регистрийн дугаар	Утасны дугаар	Гарын үсэг
1.				
2.				
3.				
4.				
5.				

Газар зүйн нэрийг тодруулах ажлыг гүйцэтгэгч:

.....
(Байгууллагын нэр, тамга)

.....
(Албан тушаал, овог нэр, гарын үсэг, огноо)

.....
(Албан тушаал, овог нэр, гарын үсэг, огноо) .


Газар зүйн нэрийг өөрчлөх хүсэлтийн маягт (өргөдөл)

Зөвхөн албан хэрэгцээнд:

	Хүсэлт (өргөдөл) гаргагчийн мэдээлэл (Иргэн, Аж ахуйн нэгж, Төрийн байгууллага, Төрийн бус байгууллага болон бусад)		Овог, нэр: РД: Оршин суугаа хаяг: Утас: Факс: И-мэйл: Гарын үсэг: Хавсралт баримтын хуудасны тоо: _____ Огноо: _____
1.	Батлагдсан газар зүйн нэр	оноосон нэр дэвсгэр нэр	<input type="radio"/> Арал Төвөө <input type="radio"/> уул
2.	Батлагдсан огноо:		2003 оны 10 дугаар сарын 31-ний өдөр
3.	Батлагдсан тогтоол, шийдвэрийн дугаар		42 дугаар тогтоол
4.	Баталсан этгээдийн нэр		Улсын Их Хурал
5.	Батлагдсан газар зүйн нэрийн байршил		<input type="radio"/> ЗЗНДН-ийн доторх байрлал <input type="radio"/> Хилийн зааг
6.	Газар зүйн нэрийг өөрчилж буй шалтгаан (тайлбар бичих)		<input type="radio"/> Монгол хэлнээс өөр хэл дээр батлагдсан <input type="radio"/> Үг, үсгийн алдаатай батлагдсан <input type="radio"/> Адил төрлийн хэд хэдэн объектын ижил нэр нь зам, тээвэр, харилцаа холбоо, бусад байгууллагын ажилд хүндрэл учруулахаар байвал <input type="radio"/> уугуул иргэд нь нэрлэж заншсан уламжлалт нэрийг сэргээх хүсэлт тавьсан <input type="radio"/> тухайн объектын мөн чанарт тохирохгүй, этгээд хэллэгээр нэрлэгдсэн байвал
7.	Санал болгож буй нэр	1 дэх нэр 2 дахь нэр	
8.	Нэрний гарал үүсэл, утга, хэл, ямар нэрнээс үүсэлтэй талаарх тэмдэглэл		
9.	Аймаг, сум, нийслэл, дүүрэг, баг, хорооны нэр, дугаар.		
10.	Хамгийн ойр орших хот, суурин газраас алслагдах зай (ямар чиглэлд, ямар зайнд). 1:100000-ны масштабтай байр зүйн зургийн нэршил		
11.	Газар зүйн нэрийн солбицол (градус, минут, секунд).		Өргөрөг: Уртраг:
12.	Нэрийн талаар мэдээллээр хангагч иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл		Овог, нэр: Регистрийн дугаар: Хаяг: Утас: И-мэйл:

13. Эрх бүхий байгууллага болон орон нутгийн зөвлөлийн зөвлөмж 1. Аймаг, сум, нийслэл, дүүргийн ЗДТГ


Гэрэл зураг (зураг дарсан зүг, чиг)




14.

Тайлбар: 1-8 ширхэг гэрэл зураг оруулах (зураг дарсан зүг, чиг бичи);
Жишээ нь: Зүүн зүгээс эсвэл Зүүн урд зүгээс гэх мэтээр бичнэ.

Байршлын зураг



15.



(Газар зүйн нэрийн зураг болон сумын схем зураг дээрх харагдах байдал)

Засгийн газрын зөвөрдүүлэгч
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛГА
 ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕР

ЭХ ХУВЬ
 Өмчлөх аянтыг нэрлэх тусмаан
 А/333

**Шинээр бий болсон газар зүйн объектод нэр өгөх хүсэлтийн маягт
(өргөдөл)**

Зөвхөн албан хэрэгцээнд:

	Хүсэлт (өргөдөл) гаргагчийн мэдээлэл (Иргэн, Аж ахуйн нэгж, Төрийн байгууллага, Төрийн бус байгууллага болон бусад)		Овог, нэр: Регистрийн дугаар: Оршин суугаа хаяг: Утас: Факс: И-мэйл: Гарын үсэг: Хавсралт баримтын хуудасны тоо: _____ Огноо: _____
1.	Санал болгож буй газар зүйн нэр	1 дэх нэр 2 дахь нэр	
2.	Нэрний гарал үүсэл		<input type="checkbox"/> Шинээр бий болсон газар зүйн объект <input type="checkbox"/> Газар зүйн уламжлалт нэр
3.	Дэвсгэр нэр (ам, булаг, гол, нуур, уул... гэх мэт)		ам
4.	Аймаг, сум, нийслэл, дүүрэг, баг, хорооны нэр, дугаар		Дундговь аймаг, Луус сум, 1-р баг Наран
5.	Хамгийн ойр орших хот, суурин газраас алслагад зай, километрээр (аль зүгт байрлахыг тодорхой бичих).		Луус сумын төвөөс зүүн урагш 13.2 км
6.	Газар зүйн нэрийн солбицол (градус, минут, секунд)		Өргөрөг: 45° 27' 23.2" Уртраг: 105° 54' 44.0"
7.	Шинээр бий болсон объектод өгөх нэр, уламжлалт газар зүйн нэрийн хэрэглэгдэж буй хугацаа (жилээр)		<input type="checkbox"/> 50 хүртэлх жил (хуучин нэр) <input checked="" type="checkbox"/> 10-50 хүртэлх жил (харьцангуй хуучин нэр) <input type="checkbox"/> 10 хүртэлх жил (шинэ нэр)
8.	Нэрийн талаар мэдээллээр хангагч иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл		Овог, нэр: Регистрийн дугаар: Хаяг: Утас: И-мэйл:
9.	Эрх бүхий байгууллага болон орон нутгийн зөвлөлийн зөвлөмж		1. Сумын ГЗНСЗ-ийн хурлын шийдвэр 2. Сумын ИТХ-ын тогтоол 3. Аймгийн ГЗНСЗ-ийн хурлын шийдвэр 4. Аймгийн ИТХ-ын тогтоол 5. ГЗБГЗЗГ-ын ГЗНСЗ-ийн хурлын шийдвэр 6. Газар зүйн нэрийн Үндэсний зөвлөлийн зөвлөмж 7. Засгийн газрын тогтоол 8. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж 9. Улсын Их Хурлын тогтоол
10.	Гэрэл зураг (зураг дарсан зүг, чиг)		

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
**ГАЗАР ЗӨХИӨН БА
 ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ӨНГӨР**

ЭХ ХУВЬ



Хэрэглээний акт нээх тушаал
 А/333



Тайлбар: 1-8 ширхэг гэрэл зураг оруулах (зураг дарсан зүг, чиг бичих);
 (Жишээ нь: Зүүн зүгээс эсвэл Зүүн урд зүгээс гэх мэтээр бичнэ).



Байршлын зураг

11.



(Газар зүйн нэрийн зураг болон сумын бүдүүвч зурагт үзүүлэгдсэн байдал)





Газар зүйн нэрийн хувийн хэрэг

Газар зүйн нэр (Монгол, Латин галиг)	Агьтын хөндий	Agityn khöndii	
Газар зүйн нэрийн дахин давтагдашгүй дугаар	B07250005		
Газар зүйн нэрийн төрөл, гарал, үүсэл	Уламжлалт нэр		
Газар зүйн нэрийн төрөл (дэвсгэр нэр)	Хөндий		
Харъяалагдах аймаг, сум, баг	Дундговь аймаг, Өлзийт сум, Буянт-1 баг		
Газар зүйн нэрийн ерөнхий байрлал, тайлбар	Өлзийт сумын төвөөс зүүн тийш 57 км, Ирмэгийн хошууны урд талын хөндий		
Газар зүйн нэрийн солбилцол	Өргөрөг 1: 44° 53' 19,919" Уртраг 1: 107° 0' 35,006" Өргөрөг 2: 44° 53' 37,145" Уртраг 2: 107° 4' 6,707"		
Газар зүйн нэрийн орших 1:25 000-ны масштабтай байр зүйн зургийн нэрэлбэр	L-48-119-A-в	Нэрийн зургийн индекс	Г-4
Бусад газрын зурагт зөв хэрэглэгдсэн байдал	1:25 000-ны зурагт	1:100 000-ны зурагт	
	үзүүлэгдээгүй	үзүүлэгдээгүй	
Газар зүйн нэрийг баталгаажуулсан актын нэр, дугаар, огноо			
Газар зүйн нэрийн байршлын зураг			
			
Газар зүйн нэрийн тодотголын үеийн нотлох баримт:	Аудио, видео бичлэг: <input type="checkbox"/> Тэмдэглэл: <input type="checkbox"/> Фото зураг: <input type="checkbox"/>		
Газар зүйн нэрийг тодруулсан иргэн, хуулийн этгээд	"Дижитал Мэппинг" ХХК 1. Э.Эрхэмбаяр 2. Г.Үүрийнцолмон		
Газар зүйн нэрийг тодруулсан газарчин (орон нутгийн)	1. Б.Мөнхцэцэг, багийн засаг дарга 2. Б.Батжаргал, багийн газарчин		
Газар зүйн нэрийн хувийн хэрэг хөтөлсөн:	(20..... оны -р сарын -ны өдөр)		






УСГААНЫ ГАЗАР ТУСГААНЫ
 ГАЗАР ЗСХИОН БХ
 ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН АР



ЭХ ХУВЬ
 Тодотголын акт нэр: Тушаал
 А/333

ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН ЗУРГИЙН ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭХ ЗАГВАР

Д/д	Дүрслэл	Тайлбар
1.		<p>Цаасны хэмжээ Газар зүй нэрийн зургийн цаасны хэмжээ А0 (841x1189мм) байна.</p>
2.	<p>ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН ЗУРАГ</p>	<p>Газар зүйн нэрийн зургийн нэр Times New Roman 60.00</p>
3.		<p>Зургийн хүрээ Calibrated Border-ийг сонгоно. Интервал нь 10"</p> <p>Геодезийн солбицол Times New Roman 14.00</p>
4.		<p>Цаасны захаас зургийн хүрээний хэмжээ Дээд: 60мм Зүүн: 30мм Баруун: 30мм Доод: 40мм</p>
5.		<p>Зургийн хүрээ, бичвэр хоорондын хэмжээ 1.5мм</p> <p>Масштаб Times New Roman 32.00</p> <p>1 сантиметрт 1.3 км багтана. Times New Roman 20.00</p>

Засгийн газрын зорилгоор
ГАЗАР ЗОХИОН БАШ
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ӨН
ЭХ ХУВЬ
Тусгаар
1/333

6.	<p style="text-align: center;">ХИЛЛЭЖ БҮЙ УЛС, АЙМАГ, СУМЫН НЭР</p> 	<p>Хиллэж буй Улс, аймаг, сумын нэр Times New Roman 24.00 Дэрэн сум Times New Roman 14.00 Хүрээний хэмжээ: 95x110мм</p>
7.	Газар зүйн нэрийн зурагт тоогоор тэмдэглэсэн нэр	Times New Roman 24.00
8.	<p style="text-align: center;">ТАНИХ ТЭМДЭГ</p> 	<p>Таних тэмдэг Times New Roman 20.00 Давхаргын бичвэр Times New Roman 14.00</p>
9.		<p>Зургийн индекс Крилл үсэг, тоогоор бичнэ. А, Б, В ... 1, 2, 3 ... (Times New Roman 32.00)</p>
10.		<p>Газрын гадаргын өнгө Өндрийн тоон загварыг ашиглахдаа сумын хил дотор газрын шаргал өнгийг (нэг төрлийн өнгө) оруулна.</p>
11.	<p>Хиллэж буй сумын хил</p>  <p>Сумын хилээс гадагш бүс (buffer)</p>	<p>Бүс татах (buffer) Сумын хилээс 5км зайтай бүс (buffer(-д газрын гадаргыг үндсэн саарал (hillshade) өнгөөр үзүүлнэ.</p> <p>Хиллэж буй сумын хил</p>


		Бүс (buffer) дотор хиллэж буй сумдын хилийн шугамыг үзүүлнэ.
12.		Хилийн шугам, давхар өнгө Аймаг, сум, багийн хилийг дунд масштабын байр зүйн зургийн таних тэмдгээр оруулна. Хилийн шугаманд ягаан уусалт өнгөөр дүрсэлнэ.
13.	<p>ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН ЗУРАГТ ТООГООР ТЭМДЭГЛЭСЭН НЭР</p> <p>ТАНИХ ТЭМДЭГ</p> <ul style="list-style-type: none"> Сумын хил Сумын хил хүрээ 	Таних тэмдэг Тухайн сумын газар зүйн нэрийн зурагт тоогоор тэмдэглэсэн нэр, хиллэж буй сум, таних тэмдгийг зургийн хүрээнд багтаан оруулна.
14.		Нэр, огноо Гүйцэтгэгч байгууллагын нэр, огноо. (Times New Roman 14.00)
15.	<p>Газар зүйн нэрийг ... онд /гүйцэтгэгчийн нэр/тодруулан тогтоов. Газарчин /нэр/ Зураг хянасан Зураг зүйн Зөвлөх инженер</p> <p>107°50'0"E</p> <p>45°10'0"N</p> <p>15мм</p> <p>40мм</p>	Тодотгол хийсэн огноо Газар зүйн нэрийг газар дээр нь тогтоосон хүний нэр, огноо, газарчины нэр, нэрийн зураг хянасан Зураг зүйн зөвлөх инженерийн нэр бичнэ. (Times New Roman 14.00)

ARCGIS ПРОГРАММЫН ТЭМДЭГТИЙН ӨНГӨ, ХЭМЖЭЭ

Таних тэмдэг (Layout)

Х -23 инч

Ү-6.5 инч




Худаг

Таних тэмдэг – Well Drilled Public

Хэмжээ - 6 (size)

Өнгө - RGB (R-0, G-169, B-230)




Сумын төв

Таних тэмдэг – Circle21

Хэмжээ -13 (size)

Өнгө - RGB (R-0, G-38, B-115)




Булаг

Таних тэмдэг – Domestic water supply

Хэмжээ - 18 (size)

Өнгө - RGB (R-0, G-197, B-255)




Багийн төв

Таних тэмдэг – Circle19

Хэмжээ -11 (size)

Өнгө - RGB (R-0, G-38, B-115)




Улсын хил

Таних тэмдэг – Dashed 1 long 1 short

Хэмжээ - 3 (size)

Өнгө - RGB (R-0, G-197, B-255)




Аймгийн хил

Таних тэмдэг – Dashed 1 long 2 short

Хэмжээ - 2 (size)

Өнгө - RGB (R-230, G-0, B-0)




Багийн хил

Таних тэмдэг – Dashed 1 long 3 short

Хэмжээ - 1 (size)

Өнгө - RGB (R-104, G-104, B-104)




Сумын хил

Таних тэмдэг – Dashed 1 long 2 short

Хэмжээ – 1.50 (size)

Өнгө - RGB (R-0, G-197, B-255)




Уусалттай хил

Таних тэмдэг – Dashed 1 long 2 short

Хэмжээ - 8 (size)

Өнгө - RGB (R-255, G-200, B-255)

Transparency 30%



НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

Газар зүйн нэр – Газрын гадарга дээрх байгалийн болон барьж байгуулсан объектуудыг өөр хооронд нь ялган таних зорилгоор оноосон болон дэвсгэр нэр;

Газар зүйн нэрийн суурь зураг – 1980-1987 оны хээрийн тодруулалтаар газар зүйн нэрийг гараар бичиж, тэмдэглэсэн 1:100000-ны масштабтай хатуу артай байр зүйн зураг);

Эх зураг – Газар зүйн нэрийн хээрийн тодотголд ашиглахаар бэлтгэсэн 1:25000, 1:100000-ны масштабтай байр зүйн зураг (газар зүйн нэрийг арилдаггүй үзгээр бичиж, тэмдэглэсэн байр зүйн зураг);

Газар зүйн нэрийг галиглах - Газар зүйн объектын нэрийг гадаад хэлэнд галиглах, тухайн хэл дээрх нэрийг авиа зүйн галиг, зөв бичих дүрмийн онцлогийг харгалзан эх хэл рүү хөрвүүлэн үзүүлэх арга;

Дэвсгэр нэр – Газар зүйн объектуудыг өөр хооронд нь ялган тодотгох нэрийг;

Таних тэмдэг - Газрын зурагт дүрслэгдэх төрөл бүрийн объект тэдгээрийн тоон болон чанарын үзүүлэлтийн геометрийн, уран сайхны, тоон ба үсгэн тэмдэглэгээ;

Уугуул – Тухайн нутагтаа төрж өссөн, байнга амьдардаг иргэн;

Газрын зураг – Дэлхийн гадарга, огторгуй ертөнцийн бусад бодит биет буюу тэдгээрийн хэсгийг хавтгайд тодорхой масштаб, тусгаг, таних тэмдэг ашиглан жижгэрүүлэн буулгаж дүрсэлсэн зураг;

Масштаб - Газрын зураг дээр газрын гадаргын биет юмсыг багасган дүрслэх харьцаа;

Төслийн мэдээллийн сан, зураг – Тодотгол хийсэн ажлын үр дүн бөгөөд Улсын Их Хурлаар батлагдаагүй газар зүйн нэрийн мэдээллийн сан, зураг;

НОРМ, НОРМАТИВ БАРИМТ БИЧГИЙН ИШЛЭЛ

1. Геодези, зураг зүйн тухай хууль;
2. Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоол “Газар зүйн нэрийн жагсаалт батлах тухай”;
3. “Барилга, байгууламжийн норм, нормативын баримт бичгийн тогтолцоо” – Засгийн газрын тогтоол, дугаар 106, 2019 он;
4. Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоол “Геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоог шинэчлэн батлах тухай”;
5. “Геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ”, БД-81–103–13, БХБЯ, 2013 он;
6. Монгол Улсын стандарт Геодези, зураг зүй. Ерөнхий нэр томъёо, тодорхойлолт MNS:3951-21 (MNS 3951:1986-ын хооронд)-ын Газрын зургийн элементүүд ба зураг зүйн дүрслэлийн арга 1105, 1103, 1107, Зураг зүйн бүтээгдэхүүн 1164, Математик зураг зүй 1217;
7. Монгол крил үсгийн латин хөрвүүлэг MNS 5217:2012.